

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН

ТОГТООЛ

___оны __сарын __өдөр

Дугаар___

Дархан

Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж
ашигласны төлбөрийн хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дах заалт, 35.1.14 дэх заалт, Авто замын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дүгээр заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Орон нутгийн авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийн хэмжээг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Тогтоолыг хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Б.Азжаргал)-д даалгасугай.
3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Аймгийн засаг даргын 2015 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн “Журам батлах, хөрөнгө гаргах тухай” А/181 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

А.ЯНЖМАА

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
... оны дугаар сарын ...-ны өдрийн ээлжит бус
... дугаар хуралдааны ... тогтоолын нэгдүгээр
хавсралт

**Орон нутгийн авто зам, замын байгууламж
ашигласны төлбөр хураамжийн хэмжээ**

Нэг. Дархан-Уул аймгийн бүртгэл /Улсын дугаар/-тай тээврийн хэрэгслээс
жилд нэг удаа авах төлбөр

Тээврийн хэрэгслийн төрөл		Хураамжийн хэмжээ (төгрөг)
Мотоцокл, Мопет		10,000
Суудлын автомашин		20,000
Ачааны автомашины даац /тн/	12,0- хүртэл	30,000
	12,1- дээш	40,000
Автобусны багтаамж /Зорчигчийн тоо/	24- хүртэл	30,000
	24- дээш	40,000
Механизм		30,000

Хоёр. Бусад аймаг, хотын бүртгэл /Улсын дугаар/-тэй тээврийн хэрэгслээс
Шалган бүртгэх товчоонд нэг удаа авах төлбөр /төгрөгөөр/

Тээврийн хэрэгслийн төрөл		Хураамжийн хэмжээ
Аюултай ачаа болон хүнд даацын авто машин		10,000
Суудлын автомашин		1,000
Ачааны автомашины даац /тн/	12,0- хүртэл	2,000
	12,1- дээш	3,000
Автобусны багтаамж /Зорчигчийн тоо/	24- хүртэл	2,000
	24- дээш	3,000
Механизм		5,000

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

___оны ___сарын ___өдөр

Дугаар___

Дархан

Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж
ашигласны төлбөрийн хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дах заалт, 35.1.14 дэх заалт, Авто замын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дүгээр заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймаг, сумын төвийн доторх хатуу хучилттай авто замын хөдөлгөөнд оролцох ачааны авто машины даацын хязгаарлалтад олгох замын түр зөвшөөрлийн төлбөрийн хэмжээг нэгдүгээр хавсралтаар, чиглэлийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Тогтоолыг хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Б.Азжаргал)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн “Хураамжийн хэмжээг тогтоох тухай” 10/05 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

А.ЯНЖМАА

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
... оны дугаар сарын ...-ны өдрийн ээлжит бус
... дугаар хуралдааны ... тогтоолын нэгдүгээр
хавсралт

**Аймаг сумын төвийн доторх хатуу хучилттай авто замын хөдөлгөөнд
оролцох ачааны авто машины даацын хязгаарлалтад олгох төв замын түр
зөвшөөрлийн төлбөрийн хэмжээ**

Нэг. Төв замын түр зөвшөөрлийн төлбөрийн хэмжээ

/Төгрөгөөр/

№	Хугацаа	Төлбөр хураамж
1	Төв замын түр зөвшөөрөл (1 сар)	100,000

Хоёр. Хүнд даацын ачааны авто машины хөдөлгөөнд тавих хязгаарлалт

2.1. Аймаг, сумын нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэлт хийж буй хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд дараах гудамж, замуудад түр зөвшөөрөл олгоно.

2.2. Хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон гудамж, замуудын дугаар байршил:

1. Шинэ Дархан

- 1.1. Тойргоос - Үйлчилгээний төв хүртэл урдуураа /ОНШ-101А/
- 1.2. Тойргоос – DBS-ын уулзвар – 16 давхарын уулзвар хойгуур /ОНШ-103А, ОНШ-104А/
- 1.3. Номингийн баруун 4 замын уулзвараас – Байгаль орчны уулзвар /ОНШ-105А/
- 1.4. DBS уулзвараас – Консулын уулзвар /ОНШ-107А/
- 1.5. 16 давхарын уулзвар – Батальон 1 – Хуучин нисэх хүртэл /ОНШ-109А, 112А/
- 1.6. Үйлчилгээний төв – 39-р байр – Консулын уулзвар /ОНШ-102А/
- 1.7. ОНШ-109 замаас – ШУТИС дэргэдүүр – Оюутны хотхон зам /ОНШ-120А/
- 1.8. Хээтэйгийн гол зам /ОНШ-106А/
- 1.9. АШИУИС уулвараас – ШУТИС оюутны хотхон /ОНШ-108А/
- 1.10. 2-р хорооллын зам /ОНШ-119А/
- 1.11. Хүслийн хотхоны урд уулзвараас – Мангиртын тойрог /ОНШ-121А/
- 1.12. ОИЦ-А байрнаас – 25-р хорооллын 4 замын уулзвар /ОНШ-123А/
- 1.13. DBS уулзвараас – 25-р хороолол 3-н замын уулзвар /ОНШ-124А/
- 1.14. Дархан Захын 5н замын уулзвараас – Хүслийн хотхоны уулзвар хойгуураа /ОНШ-122А/
- 1.15. 25-р хорооллын 4-н замын уулзвараас – Хөтөл хорооллын уулзвар хойгуураа /ОНШ-112А, ОНХ-130А/
- 1.16. Анагаахын уулзвараас – Үйлвэрийн район – ДЦТС-ын уулзвар /ОНШ-110А/
- 1.17. Дархан нэхийгээс – АО0401 авто зам хүртэл /ОНШ-110А/

2. Хуучин дархан

- 2.1. Тойргоос вокзалын 8-р байрны баруун булан хүртэл /ОНХ-101А/
- 2.2. Шүүхийн уулзвараас Тосгоны хараагийн гүүр хүртэл /ОНХ-103А/
- 2.3. Хүнсний үйлдвэрийн уулзвараас – БХТНийгэмлэг уулзвар /ОНХ-106А/
- 2.4. Буян захын уулзвараас – 15-р сургуулийн уулзвар хүртэл /ОНХ-108А/
- 2.5. Ус суваг ХК-ны уулзвараас – Онцгой байдлын хэлтэс хүртэл /ОНХ-116А/
- 2.6. Вокзалын 8 дугаар байрны баруун булангаас – 18-ын уулзвар /ОНХ-102А/
- 2.7. Монгол Алтны уулзвараас – Хүнсний үйлдвэрийн уулзвар /ОНХ-105А/
- 2.8. БХТНийгэмлэгийн уулзвараас – Дархан сумын захиргааны уулзвар /ОНХ-107А/

- 2.9. Жаст Ойл шатахуун түгээгүүрийн уулзвараас – Цэвэрлэх байгууламж хүртэл /ОНХ-114А/
- 2.10. Монгол алтны уулзвараас – Гэгээ дэлгүүр /ОНХ-125А/
- 2.11. Модны захын голын зам /ОНХ-123А/
- 2.12. Биржийн 5-н замын уулзвараас – Толгойтын эцсийн 3-н замын уулзвар /ОНХ-126А/
- 2.13. Ногоон зоорьны зам /ОНХ-124А/
- 2.14. Ногоон зоорьны замаас -1-р сургууль – Хүслэн төвийн уулзвар /ОНХ-124А/
- 2.15. 6-н Буудлаас – Гурил тэжээлийн үйлдвэр- Эльватор /ОНХ-104А/
- 2.16. Хараагийн гүүрнээс – Ширээ нурууний эцэс хүртэл /ОНХ-117А/
- 2.17. Дархан сумын хороолол доторх авто зам болон гэр хорооллын доторх хатуу хучилттай авто замууд

3. Тосгон

- 3.1. Тосгоны 7-н буудлаас – Тосгон хуучин эцэс далан хүртэл /ОНХ-120А/
- 3.2. Мах комбинатын уулзвараас – Хар усны төмөр замын гарам хүртэл /ОНХ-111Б/
- 3.3. Төмөр замын депогийн уулзвараас – Нефт бааз хүртэл /ОНХ-109Б/
- 3.4. Стадионоос – Хар усны төмөр замын гарам хүртэл /ОНХ-112А/

4. Хонгор, Орхон, Шарын гол сум:

- 4.1. Сумын төвийн доторх бүх хатуу хучилттай авто зам

